

Өлзийдундговь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2020 оны ээлжит хурлын тэмдэглэл

2021 – 04 – 28

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Сайнцагаан сумын 7-р багт байрлах
Өлзийдундговь ХК-ийн хурлын танхимд 2021 оны 04 сарын 28 ны өдрийн 16 цаг 20
минутанд эхлэв.

Хуралд ирвэл зохих 57 хүн 95504 ш хувьцаа эзэмшигч оролцохоос доор нэр дурьдсан
хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирснийг танилцуулав. Үүнд:

1. А.Өлзийбалжир 764 ш	7. А.Батбаяр 70 ш
2. Г.Эрдэнэбаатар 756 ш	8. Н.Буянхүү 18126 ш
3. Н.Цоож 55702 ш	9. Б.Батаа /Түвшинжаргал/ 70 ш
4. Х.Төмөрсумъяа 350 ш	10. З.Эрдэнэбилэг 70 ш
5. С.Энхжаргал /Д.Өлзиймаа/ 348 ш	11. Х.Нарантуяа 70 ш
6. О.Алтангэрэл /А.Батбаяр/ 280 ш	12. П.Аюусэд 70 ш
	Нийт 76676 ш

Хурлын дарга Н.Буянхүү нийт 76676 ш хувьцаа эзэмшигч 12 хүн хуралд ирж хурлын
ирц 80,3 хувь байгаа тул хурлаа нээж хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж хувьцаа
эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлуулав. Мөн хурлын дэгийг танилцуулж асууж
лавлах, санал хүсэлтээ илэрхийлэхэд цаг тогтоож хязгаарлахгүйг мэдэгдэж хурлыг 18 цаг
хүртэл үргэлжлүүлэн хийж дуусгахыг танилцуулав.

Хэлэлцэх асуудлын дагуу компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Н.Буянхүү
танилцуулав.

1. Хэлэлцсэн нь:

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
ТУЗ-ийн дарга Н.Буянхүү

/ Тайланг хавсаргав /

Хурлын дарга Н.Буянхүү хэлэлцэж буй асуудлаар дор бүр нь асууж танилцаж санал
хэлэх үү яах вэ гэхэд хэлэлцэх асуудлуудаа нэг мөр сонсож үг хэлж санал гаргах
асуудалдаа орох нь зүйтэй гэж хуралд оролцогчид нэгэн зэрэг санал гаргаснаар дараагийн
асуудлыг танилцуулав.

2. Хэлэлцсэн нь:

Компанийн 2021-2023 оны бизнес төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Н.Цоож танилцуулав.

/ Бизнес төлөвлөгөөг хавсаргав./

3.Хэлэлцсэн нь:

2020 оны санхүүгийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 10-ны 01 тоот тогтоолыг гүйцэтгэх захирал Н.Цоож танилцуулав. Тус компани нь 2020 онд 89441,5 сая төгрөгийн орлого олж 119284,1 сая төгрөгийн зардал гарган 29842,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Хэлэлцэж байгаа дээрх асуудлуудаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг хурлын дарга Н.Буянхүү лавласнаар асуулт үргэлжлэв.

Асуулт: А.Өлзийбалжир:

2020 онд жуулчны бааз огт ажиллаагүй юу?

Хариулт: Н.Цоож

Гадаадын жуулчин огт ирэхгүй нөхцөл бүрдсэн тул ажиллаагүй. Харин 2021 онд ямарч байсан очиж хэдэн гэрээ барьж нар салхи үзүүлэхгүй бол өт хорхой идэж элэгдэлд орж байгаа байх. Хашааг нь ч мал шөргөөж нураасан дуулдана. Ойр зуурын засварын ажил хийхээр төлөвлөөд байгаа.

Асуулт: Х.Нарантуяа:

Өнгөрсөн онд ажиллаагүй бол жуулчны баазын ажилчид чинь байгаа юу?

Хариулт: Н.Цоож

Захирал, менежер 2 нь л байгаа. Тогоочийг худалдагчаар ээлжинд ажиллуулж хадгалахыг оролдож байна. Уг нь засгийн газраас үйл ажиллагаа нь зогсож орлогогүй болсон ААН-ийн ажилчдад 200000 төгрөг олгоно гэсэн боловч Өлзийдундговь ХК борлуулалтын орлого нь буураагүй, худалдааны үйл ажиллагаа нь явагдаж байгаа учир олгохгүй гэсэн. Захирал, менежер 2-тоо 4-сарын цалингийн 50 хувийг компаниас олгосон. Ажилгүй гэртээ л байгаа.

Асуулт: П.Аюусэд:

Дэлгүүрийн борлуулалт яагаад олигтой өсөхгүй байна вэ?

Хариулт: Н.Буянхүү

Аймгийн төвд барилгын материалын дэлгүүр олон болж бүр том том заалаар борлуулдаг газруудтай болсноос гүйлгээ нь муудаж хаасан. Одоо дан хүнсний супер маркетаа л ажиллуулж байна. Манай энэ хавьд байсан МСҮТөв, ЭМГазар зэрэг байгууллагууд шинэ байранд нүүж орсноор хүний хөдөлгөөн багассан нь манай барааны борлуулалтын хэмжээ буурахад нөлөөлж байна. Бид хүнсний дэлгүүртээ тавиур нэмж байрлуулан худалдаалах барааны нэр төрлөө нэмэгдүүлэхэд анхаарч л байна.

Асуулт: Д.Түвшинжаргал:

Яагаад ашигтай ажиллахгүй байна вэ?

Хариулт: Н.Цоож

Бараа гүйлгээ болон түрээсийн орлого урд оноосоо бага зэрэг өссөн. Өнгөрсөн онд жуулчны баазын үйл ажиллагаа огт явагдаагүйгээс 1 ч төгрөгийн орлого олоогүй, харин ч сахиул цалинжуулж, зарим ажиллагсдад сул зогсолтын мөнгө олгож, газар, ҮХХ-ийн татвар төлж байна. Ковид 19 цар тахлаас болж зарим түрээслэгчид үйл ажиллагаагаа явуулахгүйгээс түрээсээ төлж чадахгүй байна. Жишээ нь: цахим тоглоомын газар бүтэн жил ажиллаагүй хаалттай, фитнес, зөв хооллолт, цайны газар, бууз баншны цех, сорбан сампингийн сургалт зэрэг газрууд хөл хорионд орж үе үе хаагдаж байгаагаас түрээс төлөхгүйгээс манайх 2020 онд 10900,0 мянган төгрөгийн орлого олох боломжоо алдсан. Манай улсад өвчин гараагүй байхад л архи, пиво борлуулахыг хориглох, УБ-т 18 градусаас доош дарс, пиво борлуулахыг зөвшөөрч байхад манай аймагт огт заруулахгүй хориглох зэргээс шалтгаалж нилээд орлого олох боломж алдагдаж ирлээ.

Хурлын дарга Н.Буянхүү өөр асуулттай хүн байгаа эсэхийг асуухад байхгүй гэснээр үг хэлж санал хүсэлт гаргах асуудалдаа оръё гэв.

А.Өлзийбалжир: Өнгөрсөн онд корона вирусээс болоод бүх л газрын ажил доголдож ажилтнаа орлоготой байлгахад хүндрэл бэрхшээл учирсан нь ойлгомжтой. Цар тахлын үед хамгийн их нэрвэгдсэн салбар бол аялал жуулчлал. 2021 онд ч энэ нөхцөл байдал сайжирна гэхэд итгэл муу байна. 2021-2023 онд мөрдөж ажиллах бизнес төлөвлөгөө боловсруулж танилцуулсан явдалд талархаж байна. Дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллахыг эрмэлзсэн төлөвлөгөө болсон байна гэж харж байна. Ирэх онуудад энэ бизнес төлөвлөгөөний дагуу идэвхи чармайлт гарган ажиллаж хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг хүртээж эхлэх байх л гэсэн хүлээлттэй байна даа.

Х.Төмөрсумъяа: Ашиглалтгүй шахам байсан 3500 м2-ын агуулахаа эзэлээр ч гэсэн худалдсан болохоор орж ирэх мөнгийг нь үр ашигтай эргэлдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Хойшид ашигтай ажиллах нөхцөл бүрдэж л байгаа юм бна гэсэн бодолтой л байна.

Д.Өлзиймаа: Энэ байгууллагад насаараа ажиллаад өндөр насны тэтгэвэртээ суусан ээжийн минь хувьцаа танайд байдаг. Хувьцаагаа зарж үрэхгүй л гэдэг хүн байсан даа. Та нөхдөд итгэл хүлээлгэдэг л юм даа. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх л хэрэгтэй байх.

Г.Эрдэнэбаатар: Өлзийдундговь ХК-ийн арилжааг сэргээлгэхээр хөөцөлдөж байгаа чинь зүйтэй. Компанийн хувьцааг авах, худалдах сонирхолтой хүмүүс байвал энэ боломжоор нь хангаж өгөх хэрэгтэй. Сүүлийн үед биржийн арилжаа өсч хүмүүс компаниудад хувь хөрөнгө оруулж ашиг шим хүртэх эрмэлзлэлтэй болж, энэ утгаараа хувьцаат компаниудыг сонирхох хүн нилээд бий болж байна. Ер нь хүмүүс хөрөнгө оруулж үйл ажиллагааг уул уурхай, мал аж ахуйтай уялдуулан эрчимжүүлэх боломж байж мэдэх

юм. Дан худалдаа наймааны ажил явуур муутай болоод байх шиг байна. Ер нь ХАА-н бүтээгдэхүүн бэлтгэж, дотоодын үйлдвэрүүдээ хангах, экспортод ч гаргах боломж харагдаж байна. Бонд худалдаж авах зэргээр мөнгөө эргэлдүүлэхэд онцгой анхаармаар юм. Тэгвэл үр ашигтай байх нь ойлгомжтой.

А.Батбаяр: 2021 оноос ногдол ашиг хуваарилна гэж төлөвлөж байгаад талархаж байна. Төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллах байхаа гэж найдаж байна даа.

Х.Нарантуяа: ХҮТөвийн байрны өрөө тасалгаануудыг бүгдийг л хүмүүст түрээсэлж эзэнтэй байлгахад л анхаарах хэрэгтэй байх гэж бодож байна. Түрээсийн төлбөр мөнгөө бууруулж хүн татаж байгаад жилийн дараагаас бага багаар өсгөх ч юмуу, ямар ч байсан сул өрөө тасалгаа байлгахгүйгээр ашиглалтын нь сайжруулах хэрэгтэй. Манай аймагт ажлын байр муу хүн ам орлого муутай тул аж ахуйн нэгжүүд нь нэг л сайн дэгжиж дээшлэхгүй л юм. Ингээд бизнес төлөвлөгөөгөө л сайн хэрэгжүүлж ажиллаарай гэж захъя даа. Амжилт!!!

Хурлын дарга Н.Буянхүү өөр үг хэлэх хүн байгаа эсэхийг асуухад байхгүй гэснээр хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдож үг хэлэх асуудлыг тасаллаа.

Шийдвэрлэсэн нь:

2020 онд ковид 19 цар тахалтай холбогдуулан компанийн үйл ажиллагаа хязгаарлагдмал, аялал жуулчлалын салбар огт ажиллаагүйгээс орлого хомсдон алдагдалтай ажилласан нь хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж чадаагүй гэж дүгнэн 2021-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "Бизнес төлөвлөгөө"-нд тусгасан зорилтуудаа ханган биелүүлэх, хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал зөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох

Хувьцаа эзэмшигчдэд оруулсан хөрөнгөнөөсөө үр өгөөжийн нь хүртэх нөхцлийг бүрдүүлж ажиллахыг компанийн удирдлагад үүрэг болгох

Тайлант 2020 онд компани 29842,6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байх ТУЗ-ийн шийдвэрийг баталгаажуулах

Аудитын байгууллагаар баталгаажсан тайлан тэнцлийн дүнг батлахаар тус тус шийдвэрлэв.

4. Хэлэлцсэн нь:

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг эргүүлэн сонгож, бүрэн эрхийг сунгах тухай.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул дахин сонгохоор ТУЗ-өөс шийдвэрлэсэн тухай Н.Цоож танилцуулан өөр саналтай хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг асуухад өөр санал гараагүй тул тооллогын комиссыг ажилдаа орохыг урив. Тооллогын комиссын даргаар А.Өлзийбалжир, гишүүдэд Х.Нарантуяа, Д.Өлзиймаа нарыг ТУЗ-ийн хурлаар томилсон тухай танилцуулав. Тооллогын комисс

саналын хуудас тарааж нууцаар санал хураалт явуулж дүнг нэгтгэн тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

/ Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав./

ТУЗ-ийн гишүүдийн анхдугаар хуралдаан болж ТУЗ-ийн даргаар Н.Буянхүүг улируулан сонгов.

Шийдвэрлэсэн нь:

Компанийн ТУЗ-ийн гишүүдэд Н.Цоож, Н.Буянхүү, Д.Мөнх-Очир, Х.Төмөрсумъяа, Г.Эрдэнэбаатар, Н.Баярсүрэн нарыг Б.Ганбаяр, П.Аюусэд, Ц.Энхтуяа нарыг хараат бус гишүүнээр хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар сонгож батлав.

Хурлын дарга Н.Буянхүү "Өлзийдундговь" ХК-ийн 2020 оны тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон компанийн 2021-2023 оны бизнес төлөвлөгөөг батлах, 2020 оны санхүүгийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэрийг баталгаажуулах тухай 01 тоот, ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай 02 тоот тогтоолын төслүүдийг тус тус уншиж танилцуулав.

Тогтоолын төслүүдэд нэмж оруулах нэмэлт өөрчлөлт, санал байгаа эсэхийг хувьцаа эзэмшигчдээс асуухад байхгүй гэснээр хуралд оролцсон 12 хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар тогтоолын төслүүдийг батлав.

Хурлын дарга Н.Буянхүү хурлыг хааж үг хэлэв.

Хуралд хүрэлцэн ирж үнэтэй санал, зөвөлгөө өгсөн хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлье. Хувьцаа эзэмшигчдийнхээ өгсөн зөвөлгөөг ажил хэрэг болгож, хурлаар хэлэлцэн баталсан бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа эрчимжүүлж, та нөхдийн итгэлийг биелүүлж ашиг орлогоо нэмэгдүүлэн 2021 оноос эхлэн ногдол ашиг хуваарилдаг болохын төлөө хичээл зүтгэл гаргаж ажиллана. Энэ зунаас хүн амыг вакцинжуулж хорио цээрийн дэглэм гайгүй болж хүмүүс чөлөөтэй амарч, аялах нөхцөл бүрдвэл жуулчны баазын үйл ажиллагаагаа эхлүүлж дотоодын аялагч, амрагчдыг хүлээн авах болно. Түрээслэгч олж сул чөлөөтэй байгаа өрөө тасалгаагаа эзэнтэй болгоход анхаарч идэвх санаачлагатай ажиллах болно. Барааны татан авалт, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэн ашиг орлогоо нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллах болно. Та бүгдэд эрүүл энхийг хүсье гэж хэлэх үгээ өндөрлөв.

Хурлын дарга Н.Буянхүү хурлаар хэлэлцэх асуудал дууссаныг мэдэгдэж, хурал 18 цаг 10 минутанд завсарлав.

Тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга

Аюусэд

П.Аюусэд

Хянасан: Хурлын дарга

Буянхүү

Н.Буянхүү

